



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 12 сарын 08 өдөр

Дугаар А/528

Улаанбаатар хот

Баянгол дүүргийн 157 дугаар  
цэцэрлэгийн данс бүртгэлд хөрөнгө  
бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 3 дугаар зүйлийн 3.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан нийт 2,492,300 /хоёр сая дөрвөн зуун ерэн хоёр мянга гурван зуун/ төгрөгийн үнэ бүхий эргэлтийн бус хөрөнгийг данс бүртгэлд бүртгэн авахыг Баянгол дүүргийн 157 дугаар цэцэрлэг /Д.Бурмаа/-т зөвшөөрсүгэй.

2. Өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянгол дүүргийн 157 дугаар цэцэрлэг /Д.Бурмаа/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГА  М.БАЯРАА



115060001423

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2020 оны 12 дүгээр сарын 08 -ны өдрийн АБЗ дугаар тушаалын хавсралт

Бүртгэлд авах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянгол дүүргийн 157 дугаар цэцэрлэг

№	Эд хөрөнгийн нэр	Марк дугаар, үзүүлэлт	Ашиглалтад орсон огноо	Чанар байдал	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Бүртгэлийн үнэ		Хандивлагч байгууллага	
							Нэгжийн үнэ	Нийт үнэ	Нэр	Эх үүсвэр
1	Зурагт	Арина, 50 инч	2020	сайн	ш	1	716,300.00	716,300.00	Эцэг эхчүүд	Хандив
2	Зурагт	LG, 42 инч	2020	сайн	ш	1	440,000.00	440,000.00		
		Машин, тоног төхөөрөмжийн дүн						1,156,300.00		
3	Хивсэн Дрож	улаан	2020	сайн	м	32	23,000.00	736,000.00	Оюуны хөгжлийг дэмжих академи	Хандив
4	Ширээ	ДСП, цагаан	2020	сайн	ш	6	100,000.00	600,000.00		
		Тавилга, эд хогшлын дүн						1,336,000.00		
		Бүртгэх хөрөнгийн дүн						2,492,300.00		